

## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөлөнбуйр сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/012/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Аудитор С.Төмөрхуяг

Утас: 70584207 Цахим хаяг: [Tumurkhuyags@audit.gov.mn](mailto:Tumurkhuyags@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-6
3. Аудитын илрүүлэлт .....	15-16
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

2026.03.25 № 466  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН  
ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ю.ЦЭПЭЛМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөлөнбуйр сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох 7.3 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

### Бусад асуудлын хэсэг

Хөлөнбуйр сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 сарын 28-ны өдрийн 08/02 дугаар тогтоолоор "Хангалттай", аймгийн Засаг даргын 2025 оны 12 сарын 17-ны Б/30 дугаар захирамжаар 85.2 хувь гэж үнэлсэн байна.

2126050222

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>800,637.88</b>	<b>730,858.25</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	433,716.44	415,488.69
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	158,730.8	91,951.26
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	208,190.64	163,152.36
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	0	60,265.94
6	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,523,199.79</b>	<b>4,891,541.94</b>
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,523,199.79	4,891,541.94
8	1.2.2.02 Биет хөрөнгө		4,386,274.79	4,754,991.94
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	136,925	136,550
10	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>5,323,837.67</b>	<b>5,622,400.19</b>
11	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>3,659.86</b>	<b>170,788.98</b>
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		3,659.86	170,788.98
13	2.1.1.03 Өглөг		3,659.86	170,788.98
14	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,320,177.81</b>	<b>5,451,611.22</b>
15	<b>2.2.1 Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>5,320,177.81</b>	<b>5,451,611.22</b>
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		774,129.87	774,129.87
17	2.2.1.02 Хуримтлагдсан үр дүн		4,403,578.32	4,535,011.72
18	2.2.1.03 Өмнөх үеийн үр дүн		4,234,778.00	4,403,578.32
19	2.2.1.04 Тайлант үеийн үр дүн		168,800.30	131,433.40
20	2.2.1.05 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		142,469.62	142,469.62
21	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>5,323,837.67</b>	<b>5,622,400.19</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>2,509,518.64</b>	<b>2,839,853.45</b>
2	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>465,841.82</b>	<b>435,574.27</b>
3	<b>1.1.1.03.1 Орлогын албан татвар</b>		<b>352,298.95</b>	<b>359,957.25</b>
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		378,555.17	389,957.25
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-26,256.22	-30,000
6	<b>1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар</b>		<b>79,872.84</b>	<b>69,836.16</b>
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		33,670.02	5,780.85
8	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	<b>427,859.74</b>	<b>2,404,279.19</b>
9	<b>1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого</b>		<b>427,859.74</b>	<b>919,739.32</b>
10	1.1.1.04.3 Тусламжийн орлого			1,201,466.94
11	1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		307,818.27	283,072.92
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,307,998.81	-
13	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>2,041,489.06</b>	<b>2,208,492.3</b>
14	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>2,041,489.06</b>	<b>2,208,492.3</b>
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,990,927.25	2,161,987.76
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		698,604.26	875,638.49
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		84,301.04	100,752.88
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		527,409	551,621.17
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		35,809.6	39,370.39
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		370.00	2,155
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		40,662.6	49,730.75
22	1.1.2.01.1.07 Томиллолт, зочны зардал		11,769	11,015.8
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		60,556.19	90,207.48
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		531,445.57	441,495.79
25	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>50,561.81</b>	<b>46,504.55</b>
26	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>468,029.58</b>	<b>631,361.15</b>
27	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		299,229.3	499,927.75
28	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-299,229.3	-499,927.75
29	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>168,800.28</b>	<b>131,433.4</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,400,428.11</b>	<b>2,243,640.59</b>
2	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>465,841.82</b>	<b>435,574.27</b>
3	<b>1.1.1.1.03.1 Орлогын албан татвар</b>	<b>352,298.95</b>	<b>359,957.25</b>
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26,256.22	-30,000
5	<b>1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар</b>	<b>79,872.84</b>	<b>69,836.16</b>
6	<b>1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>33,670.02</b>	<b>5,780.85</b>
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,413.19	611.68
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	32,256.83	5,169.18
9	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>318,769.21</b>	<b>1,808,066.33</b>
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	318,769.21	299,789.41
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	1,225,204.00
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	283,072.92
13	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,615,817.08</b>	<b>0</b>
14	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,845,764.76</b>	<b>1,910,048.42</b>
15	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,845,764.76</b>	<b>1,910,048.42</b>
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,795,202.95	1,863,543.87
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733,914	928,117.23
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,466.04	100,752.88
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	629,513.28	605,556.24
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	34,077.93	25,795.03
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	470	2,155
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	40,847.1	62,491.75
23	1.1.1.2.01.1.07 Томиллолт, зочны зардал	11,769	11,015.8
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,718.55	2,605.4
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	248,427.05	125,054.54
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,561.81	46,504.55
27	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>554,663.35</b>	<b>333,592.18</b>
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	325,633.73	351,819.92
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	325,633.73	351,819.92
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	325,633.73	351,819.92
31	<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-325,633.73</b>	<b>-351,819.92</b>
32	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>229,029.62</b>	<b>-18,227.75</b>
33	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>204,686.82</b>	<b>433,716.44</b>
34	<b>1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>433,716.44</b>	<b>415,488.69</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	<b>1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,151,377.54</b>		<b>5,151,377.54</b>
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,151,377.54		5,151,377.54
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	168,800.28		168,800.28
4	<b>1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,320,177.81</b>		<b>5,320,177.81</b>
5	<b>1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,320,177.81</b>		<b>5,320,177.81</b>
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,320,177.81		5,320,177.81
7	1.7 Тайлант үеийн үр дүн	131,433.4		131,433.4
8	<b>1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,451,611.22</b>		<b>5,451,611.22</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,874,858.30</b>	<b>3,826,972.23</b>
2	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>428,030.00</b>	<b>435,574.26</b>
3	<b>3.1.01.1.1.1 Орлогын албан татвар</b>	<b>358,220.00</b>	<b>359,957.24</b>
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	388,220.00	389,957.24
9	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	30,000.00
11	<b>3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар</b>	<b>60,310.00</b>	<b>69,836.16</b>
12	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	7,400.00	7,454.06
13	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,910.00	1,916.00
14	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	50,000.00	60,466.10
15	<b>3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>9,500.00</b>	<b>5,780.85</b>
16	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,500.00	611.67
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	6,000.00	5,169.17
20	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>3,446,828.30</b>	<b>3,391,397.96</b>
21	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	198,103.20	199,226.01
25	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,958,393.90	2,909,099.04
28	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	290,331.20	283,072.92
30	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,364,387.00</b>	<b>3,856,968.05</b>
31	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,787,655.60</b>	<b>3,505,148.12</b>
32	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,738,994.00</b>	<b>1,676,785.83</b>
33	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,503.70	872,995.14
37	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,616.00	100,752.88
43	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	557,643.00	551,177.56
47	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	34,730.90	23,739.38
53	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,755.00	1,755.00
55	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	67,125.90	62,491.75
59	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	17,018.70	11,015.80
61	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,311.60	2,605.39
69	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	62,289.30	50,252.91
72	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,661.60</b>	<b>1,828,362.29</b>
73	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,781,857.74
75	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	48,661.60	46,504.54
78	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>465,131.20</b>	<b>351,819.92</b>
79	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	465,131.20	351,819.92
80	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	111,600.20	-
81	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	111,600.20	-
83	<b>4 Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>428,297.87</b>
84	<b>5 Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>398,297.87</b>
85	<b>6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>-</b>	<b>28</b>
86	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	2
87	6.1.01 Төсвийн байгууллага	-	2
88	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	26
89	6.2.01 Удирдах ажилтан	-	7
90	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	-	13
91	6.2.03 Үйлчлэх ажилтан	-	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>96,962.7</b>
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,962.7
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	96,962.7
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,667.7
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,295.0
II	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>79,830.9</b>
21	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>79,830.9</b>
210	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>79,830.9</b>
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,573.7
2104	1.1.1.2.1.1. Хангамж, бараа материалын зардал	2,055.7
2105	1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	400.0
2109	<b>1.1.1.2.1.1. Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,801.6</b>
4	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>17,131.8</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 26,711.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,415.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөлөнбуйр сумын 2025 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Хөлөнбуйр сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг 4 бодлого, 18 зорилт, 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, биелэлтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 08/02 дугаар тогтоолоор "Хангалттай" гэж үнэлсэн байна.

Аудитаар дүгнэхэд нийт 76 ажлаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй буюу 70-80 хувиар үнэлэгдсэн 19 ажил байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" 41.2.7-д "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг биелүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах.

2. Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Сумын нийт татварын орлогыг 358.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 359.9 сая төгрөг буюу 1.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Нийт орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 3.3 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 0.8 сая төгрөгөөр, шууд бус орлого 0.3 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна. Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл улсын тэмдэгтийн хураамж 2.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" гэж заасны 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл оруулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулсан байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ирүүлэх, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх 76 ажлаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй буюу 70-80 хувиар үнэлэгдсэн 19 ажил	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
улсын тэмдэгтийн хураамж 2.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.	1	3.7	-	-	-	-	1	3.7	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>3.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах 178 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	1	-	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>									